

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Монгол Улсын Ерөнхий
аудиторын баталсан
төлөвлөгөө, хөтөлбөрийн
дагуу хийсэн нийцлийн
аудитын тайлан

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН ҮАГ-НАГ/2018/НА-02



ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН, СУМ ХӨГЖҮҮЛЭХ
САНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ТҮҮНД ТАВИХ ХЯНАЛТЫГ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ДАГУУ ҮР ДҮНТЭЙ ЗОХИОН БАЙГУУЛААГҮЙ БАЙНА

Чойбалсан хот
2018 он

Тайланг бэлтгэсэн:
Дорнод аймаг дахь
Төрийн аудитын газрын

Дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Б.Болортуул
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд
аудитын менежер
В.Цэнгэлмаа
Утас: 70584204

Нийцлийн аудитын
албаны Аудитор
Б.Батжаргал,
Б.Одхүү
Утас: 70584207

2018 оны 11 дүгээр сар

Аудитын тайлантай
холбоотой асуудлаар
нэмж тодруулах, асууж
лавлах зүйл байвал 7058-
4204, 7058-4207 дугаарын
утас болон
www.dornod@audit.gov.mn
цахим хаягаар
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,
Хэрлэн сум, 7-р баг,
АЗДТГ-ын 2-р байр,
1 давхар 02 тоот

Агуулга

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

I Бүлэг. ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

1.1. ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөхдөө хууль, тогтоомжийн заалтыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

1.2. ОНХС-гийн хөрөнгийг хуульд нийцэхгүй арга хэмжээнд зарцуулсан байна.

1.3. ОНХС-гийн зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.4. ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажилд иргэдээс санал авах үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

II Бүлэг. СХС-гийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

2.1. СХС-гийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бодитой төлөвлөж, бүрдүүлээгүй байна.

2.2. СХС-гаас санхүүжүүлсэн нийт төслийн үр дүн 70,7 хувьтай байна.

2.3. СХС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

2.4. СХС-гийн зорилтыг хэрэгжүүлж, үр дүнг нэмэгдүүлэхийн тулд журамд өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

III Бүлэг. Өмнөх аудитаар СХС-д өгсөн албан шаардлагын хэрэгжилт 70,0 хувьтай байна.

3.1. Өмнөх оны ОНХС-гийн зарцуулалтад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

3.2. Өмнөх аудитаар СХС-д өгсөн албан шаардлагын хэрэгжилт 70,0 хувьтай байна.

ДҮГНЭЛТ

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН ХАРИУ

ЗӨВЛӨМЖ

ТУШААЛ

ТӨЛБӨРИЙН АКТ

АЛБАН ШААРДЛАГА

ХАРИУЦЛАГА ТООЦУУЛАХ ТУХАЙ САНАЛ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУ	Монгол Улс
ЗГ	Засгийн газар
НАГ	Нийцлийн аудитын газар
НА	Нийцлийн аудит
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СС	Сангийн Сайд
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ААН	Аж ахуй нэгж
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам
ХХАА	Хүнс, хөдөө аж ахуй

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй:**Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:**

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийг удирдамж болгон Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн хөгжлийн сан болон Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт хууль тогтоомжид нийцсэн эсэх, үр дүнтэй хэрэгжсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэсэн. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх
- Сум хөгжүүлэх сангийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт болон түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулсан эсэх
- Өмнөх оны аудитаар өгсөн, акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх

Аудитын хамрах хүрээ:

Аудитад аймаг, сумдын ОНХС, СХС-гийн 2017 оны төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалт, гүйцэтгэл, хяналт, тайлагналыг аймаг, сумдын ИТХ, ЗДТГ, СТСХ, Санхүүгийн хяналт, аудитын алба, багийн засаг дарга, ИНХ-ыг хамруулан шалгалаа.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуульд “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ” гэж заасан байна.

Дэлхийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Тогтвортой амьжиргаа-3” төслийн хүрээнд Монгол Улсын сумдын орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг 9 үзүүлэлтээр үнэлж, хөрөнгийн тодорхой хувиар урамшуулал олгосонд Дорнод аймгийн Баян-Уул, Булган, Дашбалбар, Сэргэлэн, Чулуунхороот, Хэрлэн сумд хамрагдаж нийт 364,6 сая төгрөгийн урамшуулал авсан байна. Улсын төсвөөс 2017 онд Дорнод аймгийн ОНХС-д 2084,0 сая төгрөг хуваарилсан байна.

Улсын төсвөөс 2011-2014 онд Дорнод аймгийн СХС-д 3359,9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Сумдын СХС-гаас 2017 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр 1011 зээлдэгчид 6906,9 сая төгрөгийн зээл олгосон байна.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхдээ Нийцлийн аудитын стандарт (АДБОУС 4000), гарын авлага, журам, удирдамжид заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, санал асуулга авах, шалгагдагч байгууллагаас

авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, давтан гүйцэтгэх, ажиглалт хийх, түүвэрчлэн шалгах зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитын шалгуур үзүүлэлт:

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болголоо.

Хууль

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль
- Жижиг дунд үйлдвэрийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

Засгийн газрын тогтоол:

- Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам /2016 оны №153/
- Наадмын санхүүжилтийн жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай /2010 оны №271/

Сангийн Сайдын түшаал:

- Орон нутгийн хөгжлийн сангийн заавар /2014 оны №43/
- Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам /2012 оны №244/

Холбогдох бусад хууль эрх зүйн актууд

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, хэлтсийн дарга бөгөөд аудитын менежер В.Цэнгэлмаа үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж нийцлийн аудитын албаны аудитор Б.Батжаргал, Б.Одхүү нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын хугацаа:

Аудитыг 2018 оны 09 дугаар сарын 15-ны өдөр эхэлж 11 дүгээр сарын 28-ны өдөр дуусган дарга бөгөөд Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулж ҮАГ болон холбогдох байгууллагуудад хүргүүлэв.

Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, холбогдох байгууллагын хариу, аудитын зөвлөмж хэсгүүдээс бүрдлээ.

Аудитын тайланд аудитын зорилтууд болох дээр дурдсан 3 асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлс, мэдээллийг хангалттай, зохистой хэмжээгээр орууллаа.

Аудитын тайланг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч, аудитын тайланг эцсийн хувилбараар боловсруулан удирдлагын зөвлөлөөр хэлэлцүүлэн Тэргүүлэх аудиторовн тушаалаар батлуллаа.


БҮЛЭГ I. ОНХС-гийн төлөвлөлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

1.1. ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөхдөө хууль, тогтоомжийн заалтыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан нь Улсын төсвөөс 2084,1 сая төгрөг, дотоод гадаадын хандив, тусламжаас 566,3 сая төгрөг, бусад орлого 36,4 сая төгрөг нийт 2686,8 сая төгрөгийн эх үүсвэрээс бүрдсэн байна.

Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуулиар ОНХНС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 2084,1 сая төгрөгөөр баталжээ. Аймгийн ОНХС-гаас Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэгт заасан хувь хэмжээний дагуу ОНХНС-гаас олгосон орлогын шилжүүлгийн 765,3 сая төгрөгийг сумын ОНХС-д, 1318,8 сая төгрөгийг аймгийн ОНХС-д хуваарилахаар төлөвлөн олгосон байна.

График 1



Аймаг сумдын ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтыг төлөвлөхдөө хууль, тогтоомжид заасан шаардлагуудыг хангасан эсэхийг үзэхэд:

Аймгийн ОНХС-гаас иргэдээс санал аваагүй “хүний хөгжлийг хангах, хөгжлийн индексийг дээшлүүлэх, аймгийн эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийн төлөө мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах, сургалт судалгаа шагнал урамшуулал, эрүүл мэнд спорт, хүүхэд боловсрол, соёл урлагийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх” гэсэн 487,0 сая төгрөгийн арга хэмжээг хандив тусламжийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр төлөвлөсөн нь **Төсвийн тухай хуулийн 60.11 дэх санал авахгүй хэрэгжүүлж болох төсөл арга хэмжээнд хамаарахгүй байгаа бөгөөд тухайлсан төсөл, төлөвлөгөө, тооцоо судалгаа байхгүй** байна.

Сумдын хувьд Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо сумдууд санал асуулгад оролцсон иргэдийн ирцийн бүртгэл байхгүй, санал асуулгын хуудсыг иргэдийн өмнөөс нэг хүнээр олон удаа бөглүүлсэн, саналын хуудсанд гарын үсэг зуруулаагүй нь **Сангийн Сайдын 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 244 дүгээр тушаалын Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 2 дугаар хавсралтад заасан шаардлагыг** хангахгүй байна.

Чулуунхороот сум нь Сумын нийтийн эзэмшлийн гудамжны гэрэлтүүлгийн зардалд 1,1 сая төгрөг, Гурванзагал сум ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны урсгал зардалд зориулж 1,0 сая төгрөг төлөвлөсөн байна.

1.2. ОНХС-гийн хөрөнгийг хуульд нийцэхгүй арга хэмжээнд зарцуулсан байна.

Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.3-д “Төсвийн тухай хуулийн 60.3-т заасан ОНХС-гаас зарцуулахыг хориглосон зүйлд зарцуулахгүй байх”, 4.4 - д “аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй 3 хөтөлбөр, төсөл арга хэмжээнд 482,6 сая төгрөгийг зарцуулсан байна.

1. Аймаг “Хүний хөгжлийг хангах, хөгжлийн индексийг дээшлүүлэх, аймгийн эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийн төлөө мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах, сургалт, судалгаа, шагнал урамшуулал, эрүүл мэнд-спорт, хүүхэд-боловсрол, соёл урлагийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх, дэмжлэг үзүүлэх” 480,5 сая төгрөг зарцуулсан байна.
2. Чулуунхороот сум Сумын нийтийн эзэмшлийн гудамжны гэрэлтүүлгийн зардалд 1,1 сая төгрөгийг зарцуулсан байна.
3. Гурванзагал сум ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны урсгал зардалд зориулж 1,1 сая төгрөгийг зарцуулсан байна.

ОНХС-гийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл болон анхан шатны баримтын бүрдүүлэлттэй холбоотой дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Цагаан-Овоо сум Айл өрхийг хашаажуулах төслийн хүрээнд 8 иргэнд гэрээ хийлгүй нийт 8,2 сая төгрөгийн хашаа олгосон байна. Эргэн төлөлтөөр 2,7 сая төгрөг төвлөрч, 5,4 сая төгрөг төлөгдөөгүй байна.
- Баян-Уул сум Спорт тоглоомын талбайн тохижилтын 10,0 сая төгрөгийн өртөг бүхий ажлыг бүрэн хүлээн аваагүй байхад гэрээ зөрчиж санхүүжилтийг бүрэн олгосон байна.
- Чойбалсан сум Хөдөөгийн багуудад гүний худгийн цооног гаргах 8,0 сая төгрөгийн ажлын гэрээнд алданги тооцох тухай заалт оруулаагүй байна.
- Булган сум Нохой устгах зардалд гарсан 0,8 сая төгрөгийн арга хэмжээний гүйцэтгэлийг гаргуулаагүй байна.
- Хөлөнбуйр сум Хөрөнгө оруулалтын 5,7 сая төгрөгийн 4 ажлын гүйцэтгэлийн баримт материал байхгүй, хөрөнгө оруулалтын 17,8 сая төгрөгийн 4 ажлын гүйцэтгэлийг хүлээн авах комиссийн тайлан дүгнэлт байхгүй.

МУ-ын Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг зарим аймаг, сумд баримтлан ажиллаагүй байна.

Хүснэгт 1 /сая.төг/

д/д	Сумдын нэр	Баяр, наадам батлан зарцуулсан	ЗГ-ын 2010 оны 271 дүгээр тогтоол	Илүү
1	Аймаг	80,0	10,0	70,0
2	Хэрлэн	10,0	5,0	5,0
3	Гурванзагал	7,0	5,0	2,0
4	Чойбалсан	6,0	5,0	1,0
5	Халхгол	6,0	5,0	1,0
	Нийт			79,0

Сумдад ОНХС-гийн дансаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг дамжуулан гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 2 /сая.төг/

д/д	Сумдын нэрс	Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний дүн	ОНХС-гийн дансаар дамжсан дүн
1	Баянтүмэн	37,0	37,0
2	Баян-Уул	35,7	35,7
3	Булган	69,3	69,3
4	Дашбалбар	16,5	16,5
5	Халхгол	14,3	14,3
6	Хөлөнбуйр	102,8	102,8
7	Цагаан-Овоо	11,6	11,6
	нийт дүн	287,4	287,4

1.3 ОНХС-гийн зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

ОНХС-гийн зааварт сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллага болон орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо хяналт тавьж ажиллахаар заасан байна. Хяналтын хороо аймгийн ИТХ болон бүх сумдын ИТХ-ын дэргэд байгуулагдсан ч нийт 14 сумаас Цагаан-Овоо, Баян-Уул, Дашбалбар, Матад, Хэрлэн сумдад хяналт тавьж ажилласан ажлын тайлан байхгүй байна. Бусад сумдын болон аймгийн Хяналтын хороо нь хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

ОНХС-гийн зааврын 9.2-д “ОНХС-гаас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн, хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ.” гэж зааснаар Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2 жилд нэг удаа ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд хяналт шалгалт хийхээр төлөвлөсөн байна. Уг төлөвлөгөөний дагуу 2016 оны ОНХС-гийн үйл ажиллагаанд 2017 онд хяналт шалгалт хийсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс нь ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт дүгнэлт өгөөгүй, цаашид хэрэгжүүлэх санал, зөвлөмжийг сум бүрээр гаргаагүй, үр дүнгийн тайланг Сангийн Яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтэст хүргүүлээгүй нь Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 10.2 дахь “Ажлын хэсэг /ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг/ ОНХС-гийн хэрэгжилтийн байдалд дүгнэлт өгөн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал, зөвлөмжийг сум, дүүрэг бүрээр гарган аймаг, нийслэлийн Засаг даргад танилцуулж, шаардлагатай бол тухайн шатны ИТХ-аар жил

бүрийн 02 дугаар сарын 25-ны дотор хэлэлцүүлнэ”, 10.3 дахь “Аймаг, нийслэл ОНХС-гийн хэрэгжилтийн үр дүнгийн жилийн тайлан, гарсан санал зөвлөмжийн хамт жил бүрийн 03 дугаар сарын 10-ны дотор Сангийн Яамны Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн хэлтэст ирүүлнэ” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

1.4 ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын ажилд иргэдээс санал авах үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны талаар нийт 14 сумын 232 иргэнээс ҮАГ-аас ирсэн санал асуулгын маягтын дагуу санал асуулга авсан.

Санал асуулгад оролцогсдын 56,5 хувь нь сангийн талаар мэдээлэлгүй, 54,3 хувь нь санал өгөх ажиллагаанд оролцож байгаагүй, 69,4 хувь нь сангийн хөрөнгөөр хийгдэж байгаа ажлуудад сэтгэл хангалуун бус, сайн мэдэхгүй гэсэн хариултыг өгсөн. /Санал асуулын дүнг аудитын тайланд хавсралтаар оруулсан./

Санал асуулгын дүнгээс харахад иргэдийн ОНХС-гийн талаар хангалттай мэдээлэлгүй, нээлттэй хэлэлцүүлэгт оролцох оролцоо сул байгаа нь харагдаж байгаа бөгөөд иргэдийн нийтийн хуралд эдийн засгийн идэвхитэй хүн ам буюу хөдөлмөр эрхэлж буй насныхны оролцоо хангалтгүй байна. Иймд ОНХС-ийн үйл ажиллагааны төлөвлөлт дэх иргэдийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд иргэдээс санал авах үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх, боловсронгуй болгох шаардлагатай байна.

БҮЛЭГ II. СХС-гийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүнд тавих хяналтыг хууль тогтоомжийн дагуу үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

2.1 СХС-гийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бодитой төлөвлөж, бүрдүүлээгүй байна.

СХС-гийн үйл ажиллагаа нь Жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмаар зохицуулагдаж байна.

Журмын 2.1-т СХС-гийн хөрөнгийг дараах эх үүсвэрүүдээс бүрдүүлэхээр заажээ. Үүнд:

- Улсын төсвөөс олгох сангийн эргэлтийн хөрөнгө
- Гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын иргэн, хуулийн этгээдийн хандив, тусламж
- Сангаас олгосон зээлийн хүүгийн орлого
- Хугацаандаа төлөөгүй зээлийн дүнд ногдуулсан алданги

СХС-гийн хөрөнгийг төлөвлөх талаар журмын 3.5-д “Сангийн үйл ажиллагааны талаар сумын Засаг дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.”, 3.5.5-д “зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх” 3.5.7-д “сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг энэ журмын 1.8-д заасны дагуу боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт ИТХ-аар батлуулах” гэж тус тус заасан байна.

Дээрх заалтуудад сумдын Засаг дарга нь СХС-гийн төсөв буюу хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэх болон зарцуулах төлөвлөгөөг боловсруулан батлуулахаар заасан ч Баянтүмэн, Булган, Баяндун, Чойбалсан сумд нь 2017 онд тухайн жилийн зээл, зээлийн хүүгийн буцаан төлөлтийн тооцоо судалгааг хийгээгүй, төвлөрүүлэх эх үүсвэр болон зарцуулалтыг төлөвлөн батлуулаагүй байна.

Цагаан-Овоо, Гурванзагал, Матад, Баян-Уул, Хэрлэн, Сэргэлэн, Халхгол, Чулуунхороот, Дашбалбар, Хөлөнбуйр сумд нь нийт 541,1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн ч зээл, зээлийн хүүгийн буцаан төвлөрүүлэх эх үүсвэрийг бүрэн тооцоогүй байна.

Сум хөгжүүлэх сангийн эх үүсвэрийг 2017 оны байдлаар дараах төрлөөр бүрдүүлсэн байна.

Хүснэгт 3 /сая.төг/

№	Аймаг, сумын нэр	2011-2014 онд улсын төсвөөс олгосон санхүүжилт	Хүү	Алданги	Гадаад дотоодын ААН байгууллагын хандив	Нийт	Тайлбар
1	Баяндун	185,1	7,9			193,0	
2	Баянтүмэн	185,1	35,1		9,0	229,2	Хот орчмын бэлчээрийн төслөөс
3	Булган	168,0	43,6			211,6	
4	Гурванзагал	168,0	23,9			191,9	
5	Дашбалбар	210,0	38,9			248,9	
6	Матад	180,1	18,4		150,0	348,5	Гадаадын хөрөнгө оруулалттай ААН-ээс өгсөн хандив
7	Халхгол	221,1	23,2			244,3	
8	Хөлөнбуйр	175,1	37,7			212,8	
9	Сэргэлэн	190,8	19,8			210,6	
10	Цагаан-Овоо	220,8	26,9			247,7	
11	Баян-Уул	226,8	12,1			238,9	
12	Чойбалсан	175,0	29,7		4,1	208,8	Хот орчмын бэлчээрийн төслөөс
13	Чулуунхороот	175,0	30,0			205,0	
14	Хэрлэн	879,2	25,2			904,4	
	Аймгийн нийт дүн	3359,9	372,4	-	163,1	3895,4	

СХС-д зээлийг хугацаандаа төлөөгүй иргэн, ААН-ээс журмын дагуу тооцох алдангийг тооцон төвлөрүүлээгүй байна.

2.2 СХС-гаас санхүүжүүлсэн нийт төслийн үр дүн 70,7 хувьтай байна.

Төрийн сангийн дансаар дамжуулан суманд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжих, тэдэнд бага хүүтэй банкны шаардлагаас гадуур зээл олгох, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор СХС-гийн хөрөнгийн эх үүсвэрээс сумын иргэн, аж ахуй нэгжид хөнгөлөлттэй зээлийг олгож байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2011-2017 онд СХС-гаас өссөн дүнгээр 1011 иргэн, ААН-д 6906,9 сая төгрөгийн зээл олгосноос 2017 оны жилийн эцсийн байдлаар 301 зээлдэгч төслөө бүрэн хэрэгжүүлээгүйгээс 1382,3 сая төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн, чанаргүй ангилалд шилжиж нийт зээлдэгчийн 70,7 хувь нь зорилтот үр дүндээ хүрсэн байна.

Сангийн үйл ажиллагааны журмын 1.11-д “Сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтын товыг эх үүсвэрийн 20-с доошгүй хувь бүрдсэн тохиолдолд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тогтооно” гэж заасан ч Баян-Уул, Булган, Чулуунхороот сумд нь дээрх нөхцөл бүрдсэн байхад 2017 онд сонгон шалгаруулалт хийж зээлийг олгоогүй байна.

Аймгийн хэмжээнд СХС нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар нийт 3441,3 сая төгрөгийн авлага тайлагнасан бөгөөд үүнээс чанаргүй зээл 1382,3 сая төгрөг буюу 40,1 хувийг эзэлж байна.

Сумд нь сангаас олгож байгаа зээлийн үндсэн төлбөр, зээлийн хүүг гэрээнд заасан графикайн дагуу бүрэн төвлөрүүлээгүй нь “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих” журмын 3.5.5 -д “Зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх” гэж заасантай нийцэхгүй байна. Мөн 2017 оны жилийн эцсийн байдлаар зээлд хамрагдсан 301 иргэн, аж ахуйн нэгж зээлийн гэрээнд заасан хугацаанд зээлийн үндсэн төлбөр, зээлийн хүүг төлөөгүй, хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн үлдэгдэлтэй байгаа нь дээрх журмын 4.7 дахь “Иргэн, хуулийн этгээд авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Сумдын Төсөл сонгон шалгаруулах зөвлөл нь зээл олгохдоо хэрэгжүүлэх төслийн төрлөөрх эрэлт хэрэгцээг судлаагүй, эдийн засгийн тооцоо судалгааг нягталж үздэггүй, журмын зарим заалтыг бүрэн мөрддөггүйгээс чанаргүй зээл үүсэх нөхцөл бий болсон байна. Тухайлбал:

Журмын 4.2.1-д заасан “тухайн суманд бүртгэлтэй буюу байнга оршин сууж үйл ажиллагаа явуулдаг байх” гэсэн шалгуурыг хангаагүй зээлдэгчид 53,0 сая төгрөгийг Сэргэлэн, Гурванзагал сумын СХС-г аас олгосон байгаа бөгөөд **Журмын 4.3.1-д заасан “тухайн сумд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх бодлогын хүрээнд орон нутгийн давуу талд түшиглэсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгох, орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байх”** гэсэн шалгуурыг бүх сумд, **4.2.3-т заасан “зээлийн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж, хугацаанд нь төлөх төлбөрийн чадвартай, барьцаа хөрөнгөтэй байх”** гэсэн шалгуурыг Баян-Уул сумаас бусад сумд анхаарч ажиллаагүй байна.

СХС-гийн хугацаа хэтэрсэн зээлд журамд зааснаар алдангийг бүрэн тооцож нэхэмжилсэн сум байхгүй байна. Тооцох алдангийг дараах хүснэгтээс харуулбал:

Хүснэгт 4 /сая.төг/

№	Аймаг, сумын нэр	Хугацаа хэтэрсэн	Иргэдийн тоо	Дутуу тооцсон алданги
1	Баяндун	147,2	16	14,5
2	Баянтүмэн	103,3	17	14,3
3	Баян-Уул	112,8	15	3,9
4	Булган	44,4	11	6,3
5	Гурванзагал	47,7	17	11,2
6	Дашбалбар	73,3	12	10,7
7	Матад	31,1	3	4,9

8	Сэргэлэн	115,1	13	4,9
9	Халхгол	42,3	8	8,2
10	Хөлөнбуйр	47,3	21	9,4
11	Хэрлэн	322,8	84	56,6
12	Цагаан-овоо	105,1	32	2,2
13	Чойбалсан	82,2	14	15,4
14	Чулуунхороот	92,5	38	24,4
	Аймгийн нийт дүн	1382,2	301	187,4

Сумд нь хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргахдаа дээрх 187,4 сая төгрөгийн алдангийг дутуу нэхэмжилсэн байгаа бөгөөд нийт 14 сумаас 11 сум нь алданги тооцох тухай гэрээнд тусгасан ч алдангийг тооцоогүй байна.

Харин Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо сумдын хувьд СХС-гаас анх зээл олгохдоо журмын шаардлага хангасан гэрээ байгуулаагүйгээс алдангийг тооцох, нэхэмжлэх боломжгүй нөхцөл үүсгэсэн байна.Үүнд:

- Баяндун сум нь 2011 онд СХС-гаас олгосон зээлийн 2 иргэний зээлийн гэрээ баримтад байхгүй, СХС-гийн баримт үдэгдээгүй, 2017 оноос өмнөх зээлдэгчидтэй байгуулсан гэрээнд хугацаа хэтэрсэн нөхцөлд тооцох алдангийн хувь хэмжээг зааж өгөөгүй, зарим гэрээг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй байна.
- Баян-Уул сум нь 2011-2012 онуудад сарын 20 хувийн алданги тооцохоор байгуулсан нь Иргэний хуулийн заалттай нийцэхгүй байна. ***Иргэний хуулийн 232.4: - анзын нийт дүн гүйцэтгээгүй үнийн дүнгийн 50 хувиас хэтэрч болохгүй, 232.6: Хууль болон гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр төлөхөөр тогтоосон анзыг алданги гэнэ.***
- Цагаан-Овоо сумд нь 2017 оноос өмнөх зээлдэгчидтэй байгуулсан гэрээнд хугацаа хэтэрсэн нөхцөлд тооцох алдангийн хувь хэмжээг зааж өгөөгүй байгаа бөгөөд мөн 2017 онд зээл олгохдоо алдангийг сарын 0,2 хувиар тооцохоор тусгасан нь ***Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 1.7 дахь “Зээлдэгч зээлийг хугацаандаа төлөөгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлөөгүй зээлийн дүнгийн 0,5 хувиас хэтрэхгүй хэмжээгээр алданги төлнө. Алдангийн хэмжээг сумын Засаг дарга болон зээлдэгчтэй байгуулах зээлийн гэрээнд тодорхой тусгана”*** гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2017 онд 111 иргэн, ААН-д 844,0 сая төгрөгийн зээл олгож, 164 ажлын байр шинээр нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 5 /сая.төг/

№	Аймаг, сумын нэр	Үүнээс								Одоо үйл ажиллагаа эрхэлж буй	Шинээр нэмэгдсэн ажлын байр
		Нийт зээлдэгч		Зориулалтын дагуу		Зориулалт бусаар					
		тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн				
1	Баяндун	-	-								
2	Баянтүмэн	-	-								
3	Баян-Уул	13	53,0	13	53,0	-	-	13	22		
4	Булган	7	45,0	7	45,0	-	-	7	11		
5	Гурванзагал	7	68,0	5	45,0	2	23,0	5	7		
6	Дашбалбар	11	107,7	11	107,7	-	-	11	18		
7	Матад	10	41,5	10	41,5	-	-	10	13		
8	Сэргэлэн	3	70,0	2	40,0	1	30,0	2	3		
9	Халхгол	9	85,0	9	85,0	-	-	9	12		
10	Хөлөнбуйр	20	84,8	20	84,8			20	24		
11	Хэрлэн	9	118,0	9	118,0			9	23		
12	Цагаан-овоо	7	50,0	7	50,0			7	10		
13	Чойбалсан	7	85,0	7	85,0			7	12		
14	Чулуунхороот	8	36,0	8	36,0			7	9		
	Аймгийн нийт дүн	111	844,0	108	791,0	3	53,0	107	164		

СХС-гаас 2017 онд олгосон зээлээс Гурванзагал, Сэргэлэн сумын 3 иргэн 53,0 сая төгрөгийн зээлийг төслийн дагуу зарцуулаагүй байна.

2.3 СХС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, хяналт тавих журам”-д зааснаар сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсэг¹, сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд жилд 2-оос доошгүй удаа шалгалт хийж, дүнг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Тэргүүлэгчдийн Хуралдаанаар хэлэлцүүлж, сумын нийт иргэдэд мэдээлэх үүрэгтэй.

Сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөл аймгийн 14 сумдын ИТХ-ын тогтоолоор байгуулагдсан ч хяналт тавьж ажилласан эсэхийг үзэхэд:

Баян-Уул, Дашбалбар, Цагаан-Овоо сумаас бусад сумдын СХС-гийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлт, тайлагналтад хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгүүд 2017 онд огт хяналт тавьж ажиллаагүй нь журмын 5.3 дахь “Энэхүү журмын 3.3.2-д заасан ажлын хэсэг сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаа, зээлийн гэрээний хэрэгжилтэд улирал бүр шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэх” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

¹ СХС-гийн журмын 3.3.2 “сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчээр ахлуулан, Засаг даргын Тамгын газрын Төрийн сангийн мэргэжилтэн, Баялаг бүтээгчдийг дэмжих холбоо болон баг тус бүрээс нэг иргэний төлөөллийг оролцуулан байгуулж ажиллах”

Хөлөнбуйр сум нь СХС-ын хяналтын ажлын зардал болох 0,3 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5.4 дэх “Сумдын Засаг дарга сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг улирал болон жилээр гаргаж, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 10-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор тухайн аймгийн Засаг даргад хүргүүлнэ”, 5.5 дахь “Аймгийн Засаг дарга энэ журмын 5.4-т заасан сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг улирлын болон жилийн тайланг нэгтгэн, улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор жижиг, дунд үйлдвэрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэсэн заалтууд нь хэрэгжихгүй байна.

Одоогийн байдлаар Хүнс хөдөө аж ахуйн газрын жижиг, дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн сумдын тайланг хүлээн авч нэгтгэн ХХААХҮЯ-ны Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлж байна.

2.4 Сангийн зорилтыг хэрэгжүүлж, үр дүнг нэмэгдүүлэхийн тулд журамд өөрчлөлт хийх шаардлагатай байна.

“Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын **3.1.4-ийн “сангаас олгосон зээлийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэн хөтөлж, холбогдох мэдээллийг Монгол банкны зээлийн мэдээллийн санд оруулах”** гэсэн заалт нь хэрэгжээгүй байгаа бөгөөд Зээлийн мэдээллийн тухай хуулийн 6.3 дахь хэсэгт заасан төрийн байгууллагын мэдэлд байгаа, иргэн, хуулийн этгээдийн зээлийн мэдээлэлд хамруулах мэдээлэлд энэ төрлийн мэдээлэл нь хамаарахгүй байна.

6.3.1.нийгмийн даатгал, татвар, гаалийн татварын төлөгдөөгүй, эсхүл хугацаа хэтрүүлж төлсөн өр, төлбөрийн дүн;

6.3.2.зээл, төлбөрийг албадан гүйцэтгүүлсэн бол албадан гүйцэтгэсэн зээл, төлбөрийн дүн, гүйцэтгэх ажиллагаа хийгдсэн он, сар, өдөр;

6.3.3.шүүхийн шийдвэр гүйцэтгэхээс санаатайгаар зайлсхийсэн, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэний улмаас эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолын он, сар, өдөр, дугаар;

6.3.4.улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон эрчим хүч, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бусдад өгөхийг хуулиар хориглоогүй мэдээлэл.

Улсын төсвөөс 2011-2014 онд Дорнод аймгийн СХС-д 3359,9 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. СХС-гаас 2017 оны жилийн эцсийн байдлаар өссөн дүнгээр нийт 1011 зээлдэгчид 6906,9 сая төгрөгийн зээл олгосон байна. Сумдын хувьд зээл олгосон хүний тоо, хугацаа хэтэрсэн буюу чанаргүй зээлийн дүнг графикаар үзүүлбэл:

График 2




График 3



Сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны талаар нийт 14 сумын жижиг дунд үйлдвэр эрхлэгч 145 иргэнээс ҮАГ-аас ирсэн санал асуулгын маягтын дагуу санал асуулга авсан.

Санал асуулгад оролцогсдын 54,5 хувь нь “сангийн талаар мэдээлэлгүй”, 24,8 хувь нь “сангаас зээл авч байсан”, зээл авч байсан иргэдийн 58,0 хувь нь “сангаас зээл авахад хүндрэл бэрхшээлтэй байсан” гэсэн хариултыг өгсөн байна. /Санал асуулгын дүнг аудитын тайланд хавсралтаар оруулсан./

Сангийн үйл ажиллагаанд улс төрийн албан тушаалтан буюу ИТХ-ын тэргүүлэгчээр ахлуулсан орон тооны бус зөвлөл хяналт тавьж, сумын Засаг даргаар ахлуулсан зөвлөл сонгон шалгаруулахаар журамласнаас шалтгаалж зээлийн олголт, эргэн төлөлттэй холбоотой хариуцлага суларч, үр дүн нь зорилго зорилтоо бүрэн хангахгүй байна. Иймд сангийн үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлж, чанаргүй зээлийн хэмжээг бууруулахын тулд журмын шинэчлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ III. Өмнөх аудитаар СХС-д өгсөн албан шаардлагын хэрэгжилт 70,0 хувьтай байна.

3.1 ОНХС-гийн үйл ажиллагаанд өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлсэн байна.

ОНХС-д 2017 онд хийгдсэн Нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага хэрэгжсэн байна.

Харин 2014 оны ОНХС-гийн зарцуулалтад хийсэн аудитаар Хэрлэн сумын ЗДТГ-т тавигдсан 67,3 сая төгрөгийн төлбөрийн актаас 21,6 сая төгрөг барагдаагүй байна. Төлбөрийн актыг барагдуулах талаар шат дараатай арга хэмжээ зохион байгуулж байсан бөгөөд ҮАГ-ын хууль, эрх зүйн хэлтэст шилжсэн байна.

3.2 Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагын хэрэгжилт 70,0 хувьтай байна.

Сум хөгжүүлэх сангийн зарцуулалт"-д 2017 онд хийсэн нийцлийн аудитаар аймгийн Засаг даргад СХС-ийн хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах талаар 1 албан шаардлага, сумын ИТХ, сумын Засаг дарга нарт нийт 7 зөвлөмж өгсөн байна.

Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээг зохион байгуулж ажиллах тухай албан шаардлагын хэрэгжилтийг сумдаар харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт 6 /сая.төг/

№	Аймаг, сумын нэр	Чанаргүй зээлтэй иргэд, ААН		Зохион байгуулсан ажил						Хууль хяналтын байгууллагад хандаагүй	
		тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн	тоо	Мөнгөн дүн
1	Баяндун	16	147,3	5	50,4	11	96,9				
2	Баянтүмэн	17	103,3			17	103,3				
3	Баян-Уул	15	113,3	4	54,3	4	19,9	7	39,2		
4	Булган	11	50,7							11	50,7
5	Гурванзагал	17	47,8	7	21,9	2	10,7	8	15,2		
6	Дашбалбар	12	73,4	4	32,5	6	36,7	2	4,2		
7	Матад	3	31,2			3	31,2				
8	Сэргэлэн	13	115,1	6	34,8	5	50,5	2	29,8		
9	Халхгол	8	42,3							8	42,3
10	Хөлөнбуйр	21	47,3			2	8,3	19	38,9		
11	Хэрлэн	84	322,8							84	322,8
12	Цагаан-Овоо	32	112,9	9	34,2	17	65,4	6	13,3		
13	Чойбалсан	14	82,2	14	82,2						
14	Чулуунхороот	38	92,6			19	45,5	19	47,1		
	Аймгийн нийт дүн	301	1382,2	49	310,3	86	468,4	63	187,7	103	415,8

Албан шаардлагын хэрэгжилт 70,0 хувьтай байгаа бөгөөд 7 зөвлөмжөөс аймгийн Засаг даргад өгсөн “өмнөх онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийг хангуулах чиглэл өгч ажиллах”, сумдын Засаг дарга нарт өгсөн “зээлийн гэрээг байгуулахдаа алдангийн хувь

хэмжээг журмын дагуу гэрээнд тусгах” гэсэн 2 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сан

1. ОНХС-гийн хөрөнгийг төлөвлөхдөө хууль, тогтоомжийн заалтыг бүрэн мөрдөж ажиллаагүй байна.
2. ОНХС-гийн хөрөнгийг хуульд нийцэхгүй арга хэмжээнд зарцуулсан байна.
3. ОНХС-гийн зарцуулалтад тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сум хөгжлийн сан

1. СХС-гийн хөрөнгийг хууль, журамд заасны дагуу бодитой төлөвлөж, бүрдүүлээгүй байна.
2. СХС-гаас санхүүжүүлсэн нийт төслийн үр дүн 70,7 хувьтай байна.
3. СХС-гийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг даргад:

Орон нутгийн хөгжлийн сан

1. ОНХС-гаас хууль, журамд нийцээгүй тооцоо судалгаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж, санхүүжүүлэхгүй байх.
2. Сумдын ОНХС-гийн хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж ажиллах.
3. МУ-ын Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг баримтлан ажиллах.

Сум хөгжүүлэх сан

1. Өмнөх онд өгсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулах чиглэл өгч ажиллах.

Сумдын ИТХ-ын дарга нарт:

Орон нутгийн хөгжлийн сан

1. Цагаан-Овоо, Баян-Уул, Дашбалбар, Матад, Хэрлэн сумдын ИТХ-аас ОНХС-

гийн үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж ажиллах.

Сум хөгжүүлэх сан

1. Сангийн төсвийг сумын төсөвт тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, сангаас олгох зээлийн дээд хязгаарыг тогтоож байх.

2. Баянтүмэн, Баяндун, Булган, Гурванзагал, Матад, Сэргэлэн, Халхгол, Хөлөнбуйр, Хэрлэн, Чойбалсан, Чулуунхороот сумд сангийн орон тооны бус хяналтын зөвлөлийг журмын дагуу ажиллуулж, ажлын тайлан дүгнэлтийг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, иргэдэд мэдээлж байх.

Сумдын Засаг дарга нарт:

Орон нутгийн хөгжлийн сан

1. Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо сумд ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих хөтөлбөр төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдийн оролцоог хангаж ажиллах.

Сум хөгжлийн сан

1. Баянтүмэн, Булган, Баяндун, Чойбалсан сумд СХС-гийн төсвийг буцаан төвлөрүүлэх зээл, зээлийн хүүгийн орлогын тооцоонд үндэслэн төлөвлөж, батлуулах.

2. Баян-Уул, Булган, Чулуунхороот сумд сангийн хөрөнгийн эх үүсвэр нь 20-оос доошгүй хувь бүрдсэн тохиолдолд журамд заасны дагуу сонгон шалгаруулалт хийж, иргэдийг зээлд хамрагдах боломжоор хангах.

3. Баяндун, Баян-Уул, Цагаан-Овоо сумд зээлийн гэрээг байгуулахдаа алдангийн хувь хэмжээг журмын дагуу гэрээнд тусгаж өгөх.

4. Булган, Халхгол, Хэрлэн сумд хугацаа хэтэрсэн зээл, зээлийн хүүгийн 407,1 сая төгрөгийн авлагыг шүүхэд шилжүүлж, авлагыг барагдуулах арга хэмжээ авч ажиллах.

Аудитаар нийт 1115,1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлэн 5,7 сая төгрөгийн 2 ширхэг төлбөрийн акт тогтоон, зөрчил арилгуулах 49,2 сая төгрөгийн 6 ширхэг албан шаардлага өгч, хариуцлага тооцуулах 2 санал, 1060,2 сая төгрөгийн 12 ширхэг зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2019 оны 07 дугаар сарын 15-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 30

Чойбалсан хот

Нийцлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/146 тоот тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалт, 2017 оны А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2018 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүн”-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн актыг нэгдүгээр хавсралтаар, албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, болон Дорнод аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитор /Б.Батжаргал/-д даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР В.БОЛОРТУУЛ



11 078


Дарга бөгөөд Тэргүүлэх аудиторов
2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн
3 дугаар тушаалын хавсралт 1



Төлбөрийн актын жагсаалт

№	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлага	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Цагаан-Овоо сум	ҮАГ-НАГ/2018/НА-02	01/51	5,4
2	Хөлөнбуйр сум	ҮАГ-НАГ/2018/НА-02	02/52	0,3
Нийт дүн				5,7

Дарга бөгөөд Тэргүүлэх аудиторовын
2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн
30 дугаар тушаалын хавсралт 2



Албан шаардлагын жагсаалт

№	Байгууллагын нэр	Нийцлийн аудитын дугаар	Төлбөрийн акт, албан шаардлага	Мөнгөн дүн /сая төгрөг/
1	Халхгол сум	ҮАГ-НАГ/2018/НА-02	01/42	6,0
2	Гурванзагал сум	ҮАГ-НАГ/2018/НА-02	03/44	8,0
3	Хэрлэн сум	ҮАГ-НАГ/2018/НА-02	04/45	10,0
4	Чулуунхороот сум	ҮАГ-НАГ/2018/НА-02	05/46	1,1
5	Чойбалсан сум	ҮАГ-НАГ/2018/НА-02	06/47	14,0
Нийт дүн				39,1